



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 03 дугаар сарын 09

№ 01/77 4УА-2018/88/СТА ТЧС Мандалговь хот

Г

Т

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Нэгдүгээр цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аudit хийх явцад хүүхдийн хоолны нормыг мөрдөөгүй **663,665.00** /Зургаан зуун жаран гурван мянга зургаан зуун жаран таван/ төгрөгийн хүнсний материалыг зөрүүтэй олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /Батлагдсан төсөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн өрөнхийлон захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтэгдэхүүний жишиг”-т заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зорчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага огөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсон/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Батлагдсан норм, нормативийг мөрдөж, тооцоог бодож ажиллах;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Сайнцагаан сумын Нэгдүгээр цэцэрлэгийн төсвийн шууд захирагч М.Борхүүхэн, нягтлан бодогч Л.Буян-Эрдэнэ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ	
ӨГСӨН¹:	ЗӨВШӨӨРСӨН:
АУДИТОР <i>Т.ОЮУН-ЭРДЭНЭ</i>	ДАРГА <i>М. БҮН</i>
	М.БОРХҮҮХЭН
	НЯГТЛАН БОДОГЧ <i>Л.БУЯН-ЭРДЭНЭ</i>

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрээг ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.